Сэндли
БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 10 сарын 13 -ны өдөр № 20 Улаанбаатар хот

Аудитын байгууллага сонгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.10 дахь заалт, Сэндли ББСБ (цаашид "Компани" гэх) ХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6.7 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудит, эрсдэлийн удирдлагын хорооны 2026 оны 10 дүгээр сарын 09-ны өдрийн 04 тоот тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Компани нь "Бэйкер тилли далайван аудит" ХХК-ийг компанийн 2026 оны санхүүгийн тайланд хөндлөнгийн аудитын дүгнэлт гаргах байгууллагаар сонгосугай.

2. Энэхүү тогтоолын дагуу "Бэйкер тилли далайван аудит" ХХК-тай холбогдох гэрээ байгуулах, гарын үсэг зурах, гэрээний үнийг тогтоох бүрэн эрхийг Гүйцэтгэх захирал (Б.Одгэрэл)-д олгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Б.НАРАНБАТ

Сэндли
БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 10 сарын 13-ны өдөр № 21 Улаанбаатар хот

Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалт, "Сэндли ББСБ" ХК (Цаашид "Компани" гэх)-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6.20 дахь заалт, Нэгдмэл сонирхолтой этгээдтэй хийх хэлцэл, сонирхлын зөрчлийг зохицуулах журмын 3 дугаар зүйлийн 3.5 дахь хэсгийг тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Компани нь ногоон орон сууцны зээлийн бүтээгдэхүүн шинээр гаргаж буйтай холбоотойгоор Хавсралт 1-д заасан "Неосити" төслийн орон сууцыг борлуулах эрх бүхий байгууллагуудтай Хамтран ажиллах гэрээ, Хүү хуваах гэрээ, Баталгааны гэрээ, Зээлийн шугамын гэрээ буюу сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрсүгэй.

2. Сонирхлын зөрчилтэй хэлцлийг компанийн үйл ажиллагааны үр ашиг, санхүүгийн тогтвортой байдал, эдийн засгийн ашиг сонирхолд нийцүүлэн, компанид бодитой үр өгөөж бий болгох нөхцөлөөр байгуулахыг зөвшөөрсүгэй.

3. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхтэй холбоотой шийдвэр гаргахад сонирхлын зөрчилгүй ТУЗ-ийн гишүүдийн олонхийн саналаар баталсныг тэмдэглэсүгэй.

4. Энэхүү тогтоолын 1-д дурдсан эрх хэмжээний хүрээнд сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулах эрхийг Гүйцэтгэх захирал (Б.Одгэрэл)-д олгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА
Б.НАРАНБАТ